



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 661  
танай ны № т

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ  
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Б.Отгонхишигийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн Төлөөлөгчдийн Хурлын 6817 - 1 : 2020 Төрийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-

006021336

2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Б.Отгонхишиг Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 даугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Б.Отгонхишигийн мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Б.Отгонхишигд

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Б.ОТГОНХИШИГИЙН  
МОРИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Хүн амын хөгжил, нийгмийн бодлого

**1.1 Эрүүл мэндийн бодлого**

- 1.1.1 Эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусlamж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрт илрүүлэгт багийн иргэдийг хамруулах бодлогыг баримтлана.
- 1.1.2 Хүн амын эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах зан үйлийг төлөвшүүлэн, хүүхэд залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эмийн зохистой хэрэглээг сурталчлах бодлогыг хэрэгжүүлнэ.

**1.2 Боловсролын бодлого**

- 1.2.1 Сургуулийн дотуур байрны болон цэцэрлэгийн хатуу зөвлөн эдлэлүүдийг үе шаттай шинэчлэх, хүүхдүүдийн амьдрах ая тухтай нөхцлийг бүрдүүлэх бодлогоор хангана.
- 1.2.2 Хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

**1.3 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого**

- 1.3.1 Өрхийн жижиг үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдийг зээлийн мэдээллээр хангах, сургалт хөтөлбөрт хамруулах замаар бизнесийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

Хоёр.Эдийн засгийн хөгжлийн бодлого

**2.1 Хөдөө аж ахуйн бодлого**

- 2.1.1 Малчин өрх, малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл нь бизнесийн өөр төрлийн үйл ажиллагаанаас орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх бодлогыг баримтална
- 2.1.2 Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.3 Иргэдийг хүнсний ногоо, ногоон тэмжээл тариалах үйл ажиллагааг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

**2.2 Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний бодлого**

- 2.2.1 Сумын брэнд бүтээгдэхүүн бий болгох, малчдын сүү, цагаан идээ боловсруулах чадамж, үр өгөөжийг сайжруулах бодлогыг дэмжинэ.

**2.3 Дэд бүтэц**

- 2.3.1 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг боломжит бүх байршилд нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

Гурав. Нутгийн захиргаа, хууль эрх зүйн ажил үйлчилгээ

**3.1 Нутгийн захиргааны ажил үйлчилгээ**

- 3.1.1 Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.1.2 Төрийн албан хаагчдыг тогтвортой сууршилтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, залуу албан хаагчдыг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

Б.Омчижин /Б.ОТГОНХИШИГ/ 99013364

